



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/119

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, Өвөрхангай аймгийн онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад коронавируст (COVID-19) халдварын тохиолдлууд нэмэгдэж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, гадны аймагт отор нүүдлээр хаваржиж буй малчдыг эргэх, өвс тэжээл тараах зэрэгт чухал шаардлагатай байх тул аймгийн Онцгой байдлын газарт авто машин худалдан авахад 70.000.000 (далан сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлыг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч худалдан авалт хийхийг аймгийн Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Т.Мөнхдорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД